ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 01 Ховд

"Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, "Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай" хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгаас "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одонгоор 42, хоёрдугаар зэргийн одонгоор 304, бүгд 346 эхийг шагнуулахаар тодорхойлолт, материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2."Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах эхчүүдийн тодорхойлолтыг зохих журмын дагуу бүрдүүлж, Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 02 Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол улсын "Гавъяат эдийн засагч цол"-оор

1. Доньд Алтангэрэл - Жаргалант сумын иргэн

Монгол улсын " Гавъяа тээвэрчин цол"-оор

2. Нанзад Агшигнов - Жаргалант сумын Хайрхан багийн иргэн

Монгол Улсын " Гавъяат мал зүйч цол"-оор

1. Доржбалын Балдиржамц - Дарви сумын "Сутайн үүлдэр" ХХК-ны захирал

"Хөдөлмөрийн Гавъяаны улаан тугийн одон цол"-оор

1. Санжжав Цэднээ -Чандмань сумын Урд гол багийн иргэн
2. Цэрэндорж Отгонбаатар - Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга
3. Капитан Нуртай - Булган сумын Баянсудал багийн иргэн
4. Хойшыбай Шайзада - Жаргалант сумын Рашаант багийн иргэн

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 03 Ховд

Саналыг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Хилийн цэргийн 0130 дугаар ангийн 2018 оны 45/107 албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эх орныхоо тусгаар тогтнол, дархан хилийн халдашгүй бүрэн бүтэн байдлыг хангахад байгуулсан эрэлхэг гавъяа, баатарлаг үйлсийг алдаршуулан дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор Хилийн 0130 дугаар ангийн хилийн 3 дугаар /Уушиг/-ийн заставыг Монгол Улсын баатар Баясгалангийн Бадамын нэрэмжит болгох тухай ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

2.Хилийн 0130 дугаар ангийн хилийн 3 дугаар /Уушиг/-ийн заставыг Монгол Улсын баатар Баясгалангийн Бадамын нэрэмжит болгон шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох бичиг баримтыг бүрдүүлж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/ -д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 04 Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулан үр дүнг тооцож, улирал тутам Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д тус, тус үүрэг болгосугай.

ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 05 Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 2018 оны 2 дугаар улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 06 Ховд

Нэрэмжит болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гавьяат үйлстнийг алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор Манхан сумын ерөнхий боловсролын сургуулийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийг Монгол төрийн нэрт зүтгэлтэн, дархан түшээ, Монгол Улсын гавъяат эдийн засагч, Улсын Их Хурлын дарга асан Дамдины Дэмбэрэлийн нэрэмжит болгосугай.

2. Гавьяат үйлстний үйл хэргийг алдаршуулан мөнхжүүлэх талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай хамтран бүх талын арга хэмжээ авч, хөдөлмөр бүтээл, үйл хэргийг иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчлан, гавъяа, үйлсийг алдаршуулан нэр төртэй ажиллахыг Манхан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал /Ч.Энхтөр/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 13 өдөр Дугаар 07 Ховд

Нэрэмжит болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн түүхт 70 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийг Монгол Улсын гавъяат багш Гүнчингийн Дашганы нэрэмжит болгосугай.

2.Гавъяат үйлстний үйл хэргийг алдаршуулан мөнхжүүлэх талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай хамтран бүх талын арга хэмжээ авч, хөдөлмөр бүтээл, үйл хэргийг иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчилан, гавъяа, үйлсийг алдаршуулан нэр төртэй ажиллахыг Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Түвшинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 08 Ховд

Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолын 7.1 дүгээр зүйлийн 7.1.2, аймгийн ИТХ-ын 2017 оны 5 дугаар хуралдааны 5/05 тогтоолын 3 дугаар заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөст сумын Бодонч багийн нутаг дэвсгэр “Нарийн дав” хэмээх газарт 5 /таван/ га газрыг 10 /арван/ жилийн хугацаатай бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсугай.

2. Орон нутгийн тусгай хэрэгцээнд авч буй газрын булангийн цэгийн солбицлуудыг хавсралтаар баталсугай.

3. Тусгай хэрэгцээнд авч буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн биелэлтэнд хяналт тавьж, тусгай хэрэгцээнд авсан газрын зураг зүйн бүртгэл болон бичил уурхай эрхлэгчдийн нэгдсэн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлж төрийн захиргааны байгууллагад хүргүүлж холбогдох дүгнэлт гаргуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 09 Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол улсын "Хөдөлмөрийн баатар цол"-оор

1. Дорж Лхаасүрэн - Дарви сумын Мөнгөн аяга багийн иргэн Монгол улсын Гавъяат малчин

Монгол улсын "Гавъяат малчин цол"-оор

1. Цэрэннадмид Насанжаргал - Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин

Монгол улсын "Гавъяат тээвэрчин цол"-оор

1. Базар Банзрагч - Жаргалант сумын Бичигт багийн ахмад настан

Монгол улсын "Соёлын гавъяат зүтгэлтэн цол"-оор

1. Рэнцэн Даваажав - Чандмань сумын Урд гол багийн иргэн

Монгол улсын "Хүний гавъяат эмч цол"-оор

1. Шаравжамц Бийра - Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон-гоор

1. Цэрэндорж Отгонбаатар - Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
2. Хайсаа Базар - Ховд сумын ЕБС-ын математикийн багш
3. Ергаж Бурчихбай -Жаргалант сумын Наран багийн иргэн
4. Дамбадаржаа Жаргалсайхан - Жаргалант сумын Магсаржав багийн иргэн

"Алтан гадас одон"-гоор

1. Гэмбэл Ганцог - Жаргалант сумын Бичигт багийн иргэн
2. Цэвээндорж Шүрэнцэцэг - Манхан сумын ЗДТГ-ын үйлэгч
3. Цолмондорж Ширнэн - Ховд скай ХХК-ний борлуулалтын менежер
4. Сосор Буян-Өлзий - Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин
5. Шаравжамц Баттулга - Эрдэнэбүрэн сумын Намарзан багийн иргэн
6. Баймен Темирха - Ховд сумын ЕБС-ын нярав
7. Хас-Очир Бавуудорж - Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн иргэн
8. Гөлгөн Наранцэцэг - Эрдэнэбүрэн сумын ЕБС-ын технологийн багш
9. Түмэнжаргал Намжилсүрэн - Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин
10. Бадам Нямхүү - БОЭТ-ийн онош зүйн лаборант
11. Дашхүү Буниа - БОЭТ-ийн чих хамар хоолойн тасгийн эмч
12. Цэрэндагва Эрдэнэцэцэг - БОЭТ-ийн мэс заслын тасгийн сувилагч
13. Лхагваочир Гэрэлчулуун - Бугат багийн ӨЭМТ-ийн эмч
14. Заяат Цоож - Рашаант багийн ӨЭМТ-ийн эмч
15. Раднаа Сэрдамба - Жаргалант сумын Жаргалан багийн иргэн
16. Намнан Долгор - Жаргалант сумын Буянт багийн иргэн
17. Умдэлэг Баттулга - Жаргалант сумын Тахилт багийн иргэн
18. Раваг Подгоо - Жаргалант сумын Бичигт багийн иргэн
19. Донид Нанжид - Жаргалант сумын иргэн
20. Хавдолдай Болдбаатар - Жаргалант сумын Рашаант багийн иргэн
21. Санж Отгонбаяр - Голомт банкны Ховд салбарт үйлчлэгч
22. Далхсүрэн Оюун - Манхан сумын ЕБС-ын ахмад багш
23. Батаа Энхцэцэг - Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгт хөгжмийн багш
24. Цэрэндорж Амгалан -Аймгийн ЭМГ-ын ахмад ажилтан
25. Гаадай Мөнхөө -Манхан сумын ЭМТ-ийн ахмад ажилтан

хөгжмийн багш

26.Баасанхүү Амаржаргал - БОЭТ-ийн дотрын тасгийн их эмч

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

1. Батсүх Энхтуяа - БОЭТ-ийн төрөх тасгийн эх баригч бага эмч
5. Баянжаргал Эрдэнэчимэг - Буянт өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч
6. Бямбаа Оюунцэцэг - БОЭТ-ийн захиргаа аж ахуйн тасгийн хөтөч
7. Агьчулуун Бямбасүрэн - БОЭТ-ийн арьс харшлын тасгийн сувилагч
8. Хартолгой Цэцэгсүрэн - БОЭТ-ийн төрөх тасгийн их эмч
9. Бүргэд Алтансүх - Жаргалант сумын Бичигт багийн иргэн
10. Дорж Баатарсүрэн - Үенч сумын Нарийн гол багийн малчин
11. Мишиг Отгонбаяр - Үенч сумын Нарийн гол багийн малчин
12. Чүлтэм Баатаржав - Үенч сумын Нарийн гол багийн малчин
13. Тохтахамбай Хуспан - Ховд сумын Цагаанбургас багийн иргэн
14. Балжин Эрдэнэчулуун - Жаргалант сумын Бичигт багийн иргэн
15. Жигжидсүрэн Батсайхан - Тогтвортой амьжиргаа 3 төслийн зохицуулагч
16. Дүйнхархорлоо Дашням - Чандмань сумын өндөр настан
17. Должин Дэнсмаа - Чандмань сумын өндөр настан

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 10 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлалсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2015-2016 онд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургуулийн дэргэд байрлах спортын талбайн ажлын хавсралтад заасан 116251890 төгрөг /нэг зуун арван зургаан сая хоёр зуун тавин нэгэн мянга найман зуун ер/-ийн хөрөнгийг Прогресс сургуулийн балансад бүртгэхийг тус сургуулийн захирал /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Прогресс сургуулийн захирал /Д.Отгонтуяа/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгий бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 11 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жаргалант сумын 2016 оны орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хавсралтад заасан Ховд аймгийн Жаргалант сумын Алаг тоглой багийн 12 дугаар гудамжинд хийгдсэн гэрэлтүүлгийн ажил 12450000 төгрөг /арван хоёр сая дөрвөн зуун тавин мянга/-ийн, Тахилт багийн 8-9 дугаар гудамжинд хийгдсэн тоглоомын талбайн ажил 10000000 төгрөг /арван сая/-ийн, Баатархайрхан багийн 5 дугаар гудамжинд хийсэн гэрэлтүүлгийн ажил 12500000 төгрөг /арван хоёр сая таван зуун мянга/-ийн, Техникийн захын уулзвараас "Хөрс" шатахуун түгээх станцын уулзар хүртэлх авто замын дагуу явган зам барьж байгуулах ажил 53835591 төгрөг /тавин гурван сая найман зуун гучин таван мянга таван зуун ерэн нэг/-ийн, нийт 88785591 төгрөг /наян найман сая долоон зуун гучин таван мянга таван зуун ерэн нэг/-ийн хөрөнгийг Жаргалант сумын Хот тохижуулах газрын балансад бүртгэж авахыг Хот тохижуулах газрын дарга /П.Мягмартүвшин/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Хот тохижуулах газрын дарга /П.Мягмартүвшин/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 12 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт, Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн 2016 оны орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр аймгийн Дулааны станц, дулааны шугам сүлжээний ашиглалтын өмнөх захиргаа төрийн өмчит үйлдвэрийн газрыг төв замтай холбосон бетон зам хийх ажлын хавсралтанд заасан 47564775 төгрөг /дөчин долоон сая таван зуун жаран дөрвөн мянга долоон зуун далан тав/-ийн хөрөнгийг Жаргалант сумын Хот тохижулах газрын балансад бүртгэж авахыг тус газрын дарга /П.Мягмартүвшин/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Хот тохижуулах газрын дарга /П.Мягмартүвшин/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 13 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2016 онд ашиглалтанд орсон Ховд аймгийн Жаргалант сумын төв талбайн засвар шинэчлэлийн ажлын хавсралтанд заасан 1219900000 төгрөг /нэг тэрбум хоёр зуун арван есөн сая есөн зуун мянга/-ийн үнэ бүхий хавсралтанд тусгагдсан хөрөнгийг Жаргалант сумын Хот тохижуулах газрын балансад бүртгэхийг тус газрын дарга /П.Мягтартүвшин/-т зөөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Хот тохижуулах газрын дарга /П.Мягмартүвшин/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 14 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт, Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Жаргалант сумын Домбот орон сууцны хорооллоос хуучин Нисэх буудлын гурван замын уулзвар хүртлэх 300 метр явган хүний зам хийх ажлын хавсралтанд заасан 9950000 төгрөг /есөн сая есөн зуун тавин мянга/-ийн хөрөнгийг Хот тохижуулах газрын балансад бүртгэж авахыг тус газрын дарга /П.Мягмартүвшин/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Хот тохижуулах газрын дарга /П.Мягмартүвшин/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 15 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт, Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Жаргалант сумын их тойргийн авто замын дагуух явган хүний замын угсралтын ажлын хавсралтанд заасан 44190000 төгрөг /дөчин дөрвөн сая нэг зуун ерөн мянга/-ийн хөрөнгийг Жаргалант сумын Хот тохижуулах газрын балансад бүртгэж авахыг тус газрын дарга /П.Мягмартүвшин/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Хот тохижуулах газрын дарга /П.Мягмартүвшин/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 16 Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2, 7.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Зэрэг сумын Соёлын төвийн балансад бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусч цаашид ашиглах боломжгүй болсон хавсралтад заасан нийт гурван нэр төрлийн 3200000 төгрөг /гурван сая хоёр зуун мянга/-ийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасахыг тус сумын Соёлын төвийн эрхлэгч /Д.Зоригтбал/-д зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийг ашиглаж болох эсэхийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр үнэ тогтоон борлуулж, аймгийн өмчийн санд төвлөрүүлж бусад хөрөнгийг акт үйлдэн устгахыг Соёлын төвийн эрхлэгч /Д.Зоригтбал/-д үүрэг болгосугай

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 17 Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2, 7.5, Жаргалант сумын 2, 8, 9, 11 дүгээр цэцэрлэгүүдийн эрхлэгчдийн хүсэлт болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусч, цаашид ашиглах боломжгүй болсон 4 нэр төрлийн нийт 2137600 төгрөг /хоёр сая нэг зуун гучин долоон мянга зургаан зуу/-ийн хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар, 8 дугаар цэцэрлэгийн 3 нэр төрлийн нийт 3095300 төгрөг /гурван сая ерэн таван мянга гурван зуу/-ийн хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар, 9 дүгээр цэцэрлэгийн 2 нэр төрлийн нийт 2840215 төгрөг /хоёр сая найман зуун дөчин мянга хоёр зуун арван тав/-ийн хөрөнгийг гуравдугаар хавсралтаар, 11 дүгээр цэцэрлэгийн 5 нэр төрлийн нийт 6618139 төгрөг /зургаан сая зургаан зуун арван найман мянга нэг зуун гучин ес/-ийн хөрөнгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус акталж, бүртгэлээс хасахыг Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /Ц.Уранбилэг/, 8 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /Б.Батчимэг/, 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч /Н.Тодбаяр/, 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч /Ц.Тулга/ нарт зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн бүртгэл, хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 18 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Жаргалант сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 32 тоотоор ирүүлсэн хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан хавсралтанд тусгагдсан 7050000 төгрөг /долоон сая тавин мянга/-ийн тоног төхөөрөмжийг балансад бүртгэхийг Жаргалант сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /З.Энхцэцэг/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Жаргалант сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /З.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 19 Ховд

Нэрэмжит болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Гавьяат үйлстнийг алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор Дарви сумын Эрүүл мэндийн төвийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан тус байгууллагыг Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Монгол улсын Ардын эмч, Хүний гавьяат эмч, анагаах ухааны профессор, академич Балдангийн Жавын нэрэмжит болгосугай.

2.Гавьяат үйлстний түүхэн замнал, хөдөлмөр бүтээлийн үйл хэргийг иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчлан, гавьяа үйлсийг мөнхжүүлж алдаршуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг бүтээлчээр, нэр төртэй хэрэгжүүлж ажиллахыг Дарви сумын Засаг дарга /Д.Түмэндэмбэрэл/, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч /Б.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 14 өдөр Дугаар 20 Ховд

"Ахмад настанд үзүүлэх дэмжлэг,
үйлчилгээг эрчимжүүлэх тухай"

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, 14.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.1. Ахмад настны талаар хэрэгжиж буй хууль тогтоомжийн талаархи мэдээлэл сурталчилгааг өргөтгөж, ахмад настанд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах арга хэмжээ авах;

1.2. Ахмад настны амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоог дэмжих, эрүүл мэндийг хамгаалахад үзүүлэх дэмжлэг, үйлчилгээг хэрэгжүүлэхэд салбар дундын бодлого зохицуулалтыг уялдуулан хангах арга хэмжээ авч, хэрэгжилтийг ахмадын байгууллагуудын төлөөллийн оролцоотой жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцож ажиллах;

1.3. Аймгийн ахмадын өргөөний тохижилтыг сайжруулан ахмадуудад хүргэх ажил, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодиттой дэмжлэг туслалцаа үзүүлэх;

1.4. Жаргалант суманд оршин сууж буй ахмад настанг орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчих асуудлыг судалж шийдвэрлэн, санхүүжилтийг жил бүрийн аймгийн төсөвт тусган хэрэгжүүлэх.

Хоёр: Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөж, Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

2.1. Ахмадын эрх ашгийг хамгаалсан төрийн бус байгууллагуудтай хамтарч ахмад настны талаар хэрэгжиж буй хууль тогтоомжийг сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл сурталчилгаа хийж, сургалт зохион байгуулан хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллах.

2.2. Ахмад настны амьдралын нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, туслах хүсэл, сонирхолтой сайн дурын байгууллага, иргэдтэй холбож өгөх, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

2.3. Эрх бүхий байгууллагаас баталсан ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ахмад настны санаачилгаар үүсгэн байгуулагдсан болон хуулинд зааснаас илүү ахмад настанг ажиллуулж буй хуулийн этгээдэд зохих дэмжлэг үзүүлж, үр дүнг тооцож ажиллах.

2.4. Ахмадын өргөө, танхим, төв байгуулж ажиллуулах, түүнд шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг сумын жил бүрийн төсөвт тусган баталж санхүүжүүлэх.

2.5. Сумын ахмадын хорооны дарга, багуудын ахмадын зөвлөлийн дарга нарт сар тутам олгох цалин, урамшууллыг судалж сумын төсөвт тусган шийдвэрлэх арга хэмжээ авах.

Гурав: Байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт ДААЛГАХ НЬ:

3.1. Ахмад настны нийтлэг эрх ашгийг хамгаалсан “Ахмад настны тухай” хуулийн мэдээлэл, сурталчилгааг өргөтгөж холбогдох заалт бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

3.2. Ахмад настны нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн чиглэлээр авах арга хэмжээний цар хүрээг өргөжүүлж, ая тухтай амьдрах нөхцөл боломжоор хангахад дэмжлэг үзүүлж ажиллах.

3.3. Байгууллагын цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах ажлыг байгууллагын тухайн жилийн төсөв, санхүүгийн төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хуулийн хэрэгжилтийг хангах.

3.4. Байгууллагын дотоодын нөөц боломжиндоо тулгуурлан ахмад настанд зориулсан чийрэгжүүлэлтийн танхим нээж тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах.

3.5. Тухайн байгууллагад олон жил бүтээлч хөдөлмөрөө зориулсан ахмад настнуудын судалгааг гаргаж төрийн дээд шагнал болон орон нутгийн шагналуудад үе шаттай тодорхойлж байх.

Дөрөв: Аймгийн ахмадын хороо /Дамбадаржаа/-д ДААЛГАХ нь:

4.1. Сум, байгууллагуудтай хамтарч ахмад настны талаарх судалгааг нарийвчлан гаргаж, тэдэнд үзүүлэх дэмжлэг, тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ авах.

4.2. Ахмад настны тухай хууль тогтоомж, тус тогтоолын хэрэгжилтийг хангахад ахмад настнуудын идэвхийг өрнүүлэн, оролцоог хангаж холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах.

4.2. Эрх бүхий байгууллагуудтай хамтарч ахмад настнуудад үзүүлж буй дэмжлэг, үйлчилгээний талаар хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоолын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцож ажиллах.

Тав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 21 Ховд

Зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Тахилт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Бурхан шашны улааны ёсны "Тэгчинчойнхорлин хийд" шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Үйл ажиллагаандаа "Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ыг удирдлага болгон ажиллахыг Бурхан шашны улааны ёсны Тэгчинчойнхорлин хийдийн тэргүүн лам /Р.Чунагсүрэн/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 22 Ховд

Зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 18 дугаар тогтоолоор батлсан "Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Есүс христийн "Хаанчлалын сайн мэдээг тунхаглагчид" шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Үйл ажиллагаандаа "Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ыг удирдлага болгон ажиллахыг Есүс христийн "Хаанчлалын сайн мэдээг тунхаглагчид" шашны байгууллагын тэргүүн /Л.Элбэгсайхан/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 23 Ховд

Зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Наран багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа исламын шашны "Шахит-Боздахтар" шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Үйл ажиллагаандаа "Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ыг удирдлага болгон ажиллахыг исламын шашны "Шахит-Боздахтар" шашны байгууллагын тэргүүн /Д.Берикбол/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 24 Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2018 онд зохион байгуулах арга хэмжээнүүдийн нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Нийтээр тэмдэглэх баяр, ойн арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүдийг салбар, байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалтын ажил өрнүүлж ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх, сургалт, семинар, урлаг спорт, соёл урлагийн болон бусад арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж хэрэгжилтийн явцын тухай хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/, Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Ганболд/ нарт тус тус даалгасугай.

4.Тус тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 25 Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль 1948 онд байгуулагдсан цагаас эхлэн сургалт хүмүүжлийн ажлыг тогтмол жигд явуулж, сургалтын таатай орчин бүрдүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг боловсролын чанарын шинэчлэлийн бодлогуудыг амжилттай хэрэгжүүлснээр сүүлийн 10 жил дараалан "Шилдэг үнэлгээтэй сургууль"-аар шалгарч 2007, 2009, 2015 оны ажлаараа аймагтаа 3 дугаар байр, 2010, 2011 онд 2 дугаар байр, 2012 онд тэргүүн байр эзэлж, ажлын амжилтууд, багш, ажилчдын уйгагүй хөдөлмөр зүтгэл, үе үеийн удирдлагуудын оновчтой бодлого төлөвлөлтийн үр дүнд улс эх орон, сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулж, сургуулиа өдрөөс өдөрт өргөжүүлэн хөгжүүлж буй сургуулийн хамт олны ажлын амжилтыг өндрөөр үнэлэн түүхт 70 жилийн ойг нь тохиолдуулан Ховд аймгийн Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийг Төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-гоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Ховд аймгийн Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийг Төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-д тодорхойлсон холбогдох баримт бичгүүдийг журмын дагуу бүрдүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 26 Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Ховд сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмчийн 2017 оны 66 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн ОХУ-д 2017 онд үйлдвэрлэсэн УАЗ-Фургон маркийн, УАЗ-3962 арлын дугаартай, саарал өнгийн, 4999 ХОУ улсын дугаартай 29733434 мянган төгрөг /хорин есэн сая долоон зуун гучин гурван мянга дөрвөн зуун гучин дөрөв/-ийн үнэ бүхий суудлын автомашиныг балансад бүртгэхийг Ховд сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Д.Ахгүл/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Ховд сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Д.Ахгүл/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгий бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 27 Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хилийн 5 дугаар отрядын 4 дүгээр /Байтагийн/ застав НАХЯ-ны сайдын 1933 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 3 дугаар хуралдааны шийдвэрээр Ховд аймгийн Булган сумын нутагт "Байтаг" нэртэй газар байгуулагдсан. 1930-1950 оны баруун хилийн тулгаралт байлдаан, зэвсэгт халдлага, дээрэм тонуултай тэмцэж, эгнээнээсээ БНМАУ-ын баатар Б.Гиваан, Б.Тэгшээ, Л.Даваадорж нарын эх оронч дыг төрүүлсэн баатарлаг түүх, дайчин замналтай тус отрядын байгуулсан гавъяа, туулсан замнал, түүхийг мөнхжүүлэх, залуу үеийн хилчдэд эх оронч үзэл төрүүлэх, анги байгууллагаараа бахархан дурсах алдрыг хойч үедээ өвлүүлэн үлдээж, домогт Үенчийн отрядын хилийн 4 дүгээр /Байтагийн/ заставыг түүхт 70 жилийн ойг нь тохиолдуулан Төрийн дээд шагнал "Цэргийн гавъяаны одон"-гоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Хилийн цэргийн 0130 дугаар ангийн 4 дүгээр заставыг Төрийн дээд шагнал "Цэргийн гавъяаны одон"-д тодорхойлсон холбогдох баримт бичгүүдийг журмын дагуу бүрдүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 28 Ховд

Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Аймгийн шагналын журам батлах тухай" 28 дугаар тогтоолын 1.2.4, 3.1.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнасугай. Үүнд:

1. Пүрэвжав Ганчимэг - Эрдэнэбүрэн сумын Намарзан багийн малчин
2. Надмид Оюундэлгэр - Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин
3. Авилхаан Жамыла - Буянт сумын иргэн
4. Сайнбаяр Пүрэвдорж - Эрдэнэбүрэн сумын Баянгол бөгийн малчин
5. Батсуурь Баасанхүү - Эрдэнэбүрэн сумын Хар-Ус багийн иргэн
6. Дорж Баттөр - Эрдэнэбүрэн сумын
7. Жантекей Закерия - Ус цаг уур орчин шинжилгээний газрын ус судлалын инженер
8. Лхамсүрэн Ганцэцэг - Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч
9. Буяндалай Оюунчимэг - Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч
10. Янсан Жүгдэрнамжил - Мөст сумын иргэн
11. Бэгзжав Цагаан - Мөст сумын иргэн
12. Лонгуу Гэндэн - Алтай сумын иргэн

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 29 Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласан Ховд аймгийн Жаргалант сумын Магсаржав багийн иргэн, Дагвын Жүгдэрбарамыг Монгол Улсын "Гавъяат эдийн засагч" цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 30 Ховд

Нийтийн дуудлага худалдаа
зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 77 дугаар зүйлийн 77.2, Төрийн өмчийн хорооны "Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай" 44 тоот тогтоолын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн ИТХ-ын ажлын албаны балансад бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, цаашид ашиглах боломжгүй болсон Ланд круйзер-80 маркийн 05-05 ХОҮ улсын дугаартай суудлын авто машиныг нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2.Нийтийн дуудлага худалдааг 2018 оны 07 дугаар сарын 31-ны өдөр аймгийн Нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3.Хавсралтад тусгагдсан хөрөнгө борлуулсан орлогын 80 хүртэлх хувийг хөрөнгө бэлтгэхэд зарцуулахыг аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д зөвшөөрсүгэй.

4.Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 31 Ховд

Саналыг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 13.9 мянган хэрэглэгчдийг 39.4 сая квт.ц-ын цахилгаанаар найдвартай хангаж, эрчим хүч ашиглалтын үеийн засвар үйлчилгээг тогтмолжуулан алдагдлыг бууруулж үр ашгийг дээшлүүлэн санхүүгийн чадавх, үр дүнгээ сайжруулан амжилт бүтээлтэй ажиллаж буй "Ховд Цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ийг Ховд аймагт эрчим хүчний салбар үүсч хөгжсөний түүхт 70 жилийн ойг тохиолдуулан төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулахаар тодорхойлсон хамт олны саналыг дэмжиж Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. "Ховд Цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ийг Төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-д тодорхойлсон холбогдох баримт бичгүүдийг журмын дагуу бүрдүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр Дугаар 32 Ховд

Саналыг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Манхан сумын ерөнхий боловсролын сургууль нь анх 1928 онд Ханбаатар хайрхан уулын хошууны " Хошуу тамгын сургууль" гэж байгуулагдсаас хойш 1963 он хүртэл бага сургууль, 1963 оноос Хөдөлмөр политехникийн сургалттай 7 жилийн сургууль, 1968 оноос 8 жилийн сургууль, 1979 оноос төвийн бүсийн тойргийн 10 жилийн сургууль, 2006 оноос 11 жилийн сургууль, 2008 оноос 12 жилийн сургалттай Ховд аймгийн урд бүсийн түшиц бүрэн дунд сургууль болон өргөжин сургалтын үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 7-р ангийг 24, 8-р ангийг 33, 10-р ангийг 26, 11-р ангийг 2, 12-р ангийг 8 дахь удаагийн төгсөлтийг хийж 16000 гаруй сурагчдыг төгсгөн одоо тус сургууль нийт 88 багш, ажилчин, 740 сурагч, хичээлийн 2 байр, гал тогоо, дотуур байр гэсэн үндсэн 4 барилгатай, спорт заал, номын сан, биеийн тамирын задгай талбай зэрэг сургалтын иж бүрэн орчныг бүрдүүлэн сургалт хүмүүжлийн ажлаа явуулж байгаа Ховд аймгийн ууган сургуулиудын нэг юм. Тус сургуулиас БНМАУ-ын баатар Ц.Олзвой, Хөдөлмөрийн баатар Б.Лувсан, төр, нийгмийн зүтгэлтэн, УИХ-ын дарга асан Д.Дэмбэрэл нар, 18 гавьяат цолтонг, 11 эрдэмтэн доктор, 2 генерал, 22 улсын аварга малчин, 60 гаруй спортын алдартнууд төрөн гарсан байна.

Тус сургууль нь байгуулагдсан цагаасаа сургалт хүмүүжлийн ажлыг тогтмол жигд явуулж, сургалтын таатай орчин бүрдүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг боловсролын чанарын шинэчлэлийн бодлогуудыг амжилттай хэрэгжүүлснээр 1998-2010 онуудад аймгийн Хүүхдийн спортын "Бага наадам"-ын 8 удаагийн аварга баг хамт олон, 1998-2010 онуудад аймгийн шатрын 10 удаагийн аварга баг хамт олон, 2008 онд аймгийн "Шилдэг үнэлгээтэй сургууль", 2009 онд аймгийн "Шилдэг үнэлгээтэй сургууль", аймгийн ЕБС-иудаас ажлын үзүүлэлтээр I байр, 2009 онд "100 буудалт даам"-ны